



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20²² он ¹² дугаар
сарын ⁰¹-ны өдөр

Дугаар ХТ/2922

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ш.АДЬШАА ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Ховд аймгийн Мянгад сумын нутаг дэвсгэрт байрлах Халзан бүрэгтэйн ордтой холбоотой асуудлаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас бэлтгэж ирүүлснийг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцахыг хүсье.

Хавсралт: ³ хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Д.АМАРБАЯСГАЛАН

000225016234



**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: 32-63-67, Факс: (976-11) 31-13-81,
<http://www.mmhi.gov.mn>

2022.11.23 № 01/3113
танай 2022.11.11 -ны № 2707 -Т

Хариу хүргүүлэх тухай

Монгол Улсын Их хурлын гишүүн Ш.Адъяагийн тавьсан асуулгатай танилцаад дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

Асуулга 1: Халзан бүрэгтэйн ордын хүдрийн биетийн орчимд 3 ашиглалтын лиценз бүртгэлтэй хүчин төгөлдөр байна. Эдгээр 3 лиценз, тус бүр хэдэн гектар, нийт хэдэн гектар талбайг эзэлж байгаа талаар.

1. Ховд аймгийн Мянгад сумын нутагт олгогдсон Бор толгой нэртэй 106.66 га талбай бүхий ашигт малтмалын MV-019329 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Монголиан лантаноиде корпораци” ХХК, Ар хүрэн нэртэй 91.39 га талбай бүхий ашигт малтмалын MV-012335 дугаартай, Халзан бүрэгтэй нэртэй 175.24 га талбай бүхий ашигт малтмалын MV-006911 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг “Монголиа нэшнл рийр ийрт корп” ХХК тус тус эзэмшиж байна.

Асуулга 2: Халзан бүрэгтэй орд орчмын дээрх 3 талбайн лиценз эзэмшигч компани болон түүний эцсийн өмчлөгчийн дэлгэрэнгүй мэдээллийг нийтэд ил болгох талаар.

2. “Монголиан лантаноиде корпораци” ХХК-ийн хувьцааг Сильерстийм ресурс ХХК, иргэн Ц.Оюун, “Монголиан нэшнл рийр ийрт корп” ХХК-ийн бүх хувьцааг Худалдаа хөгжлийн банк тус тус эзэмшиж байна. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчтэй холбоотой мэдээлэл нь opendata.burtgel.gov.mn сайтад байршдаг нээлттэй мэдээлэл юм.

Асуулга 3: Дээрх 3 ордын ашиглалтын лиценз олгохын өмнө Мянгад сумын иргэдийн хурал, багийн Нийтийн Хурлаар дэмжигдсэн эсэх талаар.

3. “Монголиан лантаноиде корпораци” ХХК нь 2015 онд ашигт малтмалын MV-019329 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл авахдаа Ашигт малтмалын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.6-д заасны дагуу “хайгуулын ажлын явцад байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу хүлээсэн үүргийг бүрэн биелүүлж ажилласан тухай баримт”-ыг Ховд аймгийн Мянгад сумын Засаг даргын 2014 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 01/249 дугаартай албан бичгээр авч геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад өгсөн. “Монголиан нэшнл рийр ийрт корп” ХХК-ийн эзэмшиж буй ашигт малтмалын MV-006911 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2004 онд, MV-012335 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2001 онд тус тус олгосон бөгөөд тухайн үед мөрдөгдөж байсан хууль тогтоомжоор ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох асуудлаар тухайн орон нутгийн өөрөө удирдах байгууллагаас санал авдаггүй байсан тул тухайн үеийн хуульд нийцүүлж тусгай зөвшөөрлийг олгосон байна.

1508 02 2646

Монгол Улсын Засгийн газрын
Хэрэг барих газар

Бичиг хэрэг

Огноо 2022-11-28

2225/14/2020 цаг минут

Асуулга 4: Тус орд газар нь цэнгэг усны арвин нөөц бүхий Ховд гол, Хар ус нуурын ай сав, эко системийн гол цэгүүд болох Хар ус нуураас 19 км, Ховд голоос 8 км, Буянт голоос 20 км, тарвас тариалалтын талбайгаас 17 км, Мянгад сумын төвөөс 19 км, Буянт сумын төвөөс 25 км-т оршдог. Энэ нь хүн мал, амьтан, нүүдлийн шувууд, газар тариалангийн бүсийн биологийн олон янз байдал, эко системийг алдагдуулах, сөрөг нөлөө үзүүлэх өндөр эрсдэлтэйг тооцоолж үзсэн эсэх талаар.

4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг дээрх ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд боловсруулж эрх бүхий байгууллагаар батлуулна. Халзан бүргэтэйн ордыг ашиглах үед байгаль орчны нарийвчилсан үнэлгээг заавал батлуулах ба энэхүү үнэлгээнд тухайн бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлийг нарийвчлан судалж, түүнийг бууруулах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусгадаг учир энэ талаарх мэдээлэл байгаль орчны нарийвчилсан үнэлгээг батлах үед тодорхой болно.

Асуулга 5: Газрын ховор элементийн эцсийн бүтээгдэхүүн гаргаж авах үйлдвэр барих эсэх талаар.

5. “Монголиан лантаноиде корпораци” ХХК нь өнөөдрийн байдлаар өөрийн эзэмшиж буй ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд орших ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулж эрх бүхий байгууллагаар батлуулаагүй байна. “Монголиан нэшнл рийр ийрт корп” ХХК нь өөрийн эзэмшиж буй ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийн талбайд орших ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг 2018 онд боловсруулж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл /ЭБМЗ/-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. Тус техник-эдийн засгийн үндэслэлд баяжуулах үйлдвэр барих талаар тусгагдсан бөгөөд ЭБМЗ-ийн 2018 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн Т/18-09-09 дугаартай дүгнэлтийн 14-т баяжуулах үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлийг тусгайлан боловсруулж, ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэхийг аж ахуйн нэгжид үүрэг болгосон. Газрын ховор элементийн эцсийн бүтээгдэхүүн гаргах үйлдвэр барих талаар техник-эдийн засгийн үндэслэлд тусгагдаагүй байна.

Асуулга 6: Хэрэв газрын ховор элементийн эцсийн бүтээгдэхүүн гаргаж авах үйлдвэр барих тохиолдолд хүдрийн олборлолт боловсруулалтаас үүсэх Хүхрийн хүчлийн хог хаягдлын менежмент хэрхэн хийх талаар.

6. Дээрх баяжуулах үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулж батлуулах үед уг үйлдвэрт ашиглагдах химийн бодисын хэмжээ тодорхой болно.

Асуулга 7: Засгийн газраас тус ордын Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн эрх бүхий аж ахуйн нэгжийн ажилд аудит хиж болох эсэх талаар.

7. Халзан бүргэтэйн ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлд тулгуурласан байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ батлагдаагүй байх тул Засгийн газрын зүгээс аудит хийх боломжгүй юм.

Асуулга 8: Хүн ам, гадаад орчны цацрагийн шарлагын тун Халзан бүрэгтэй ордын орчимд стандартаас илүү байгаа тухай иргэдийн мэдээллийг мэргэжлийн хяналтын байгууллагаар баталгаажуулсан эсэх талаар.

8. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын захирамжаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Цөмийн энергийн комисс, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын төлөөлөл бүхий ажлын хэсэг байгуулагдаж 2022 оны 11 дүгээр сарын 13-16-ны өдрүүдэд Ховд аймгийн Мянгад суманд газар дээр нь ажилласан. Энэ ажлын хүрээнд газар дээр нь цацрагийн хэмжилтүүд хийгдсэн ба

цацраг идэвхт элементийн агуулга тодорхойлох зорилгоор холбогдох дээжлэлтүүд авагдаж лабораторид өгөгдсөн байдалтай байна. Одоогоор лабораторийн шинжилгээ хийгдэж байгаа бөгөөд хариу хараахан гарч амжаагүй байна. Энэ ажлын хэсгийн хүрээнд газар дээр нь хэмжсэн хэмжилтийн үр дүн, лабораторийн шинжилгээний хариу гарсны дараа тодорхой дүгнэлт гарна.

САЙД



Ж.ГАНБААТАР